

ДОРНОД АЙМГИЙН 2018 ОНЫ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2019.01.15

Чойбалсан хот




Өрх, хүн ам: 2018 оны жилийн эцсийн байдлаар 14 сумын 67 багт 24.6 мянган өрхөд 82.1 мянган хүн амьдарч байгаагийн 55.0 хувь нь аймгийн төвд, 14.8 хувь нь сумын төвд, 30.2 хувь нь хөдөө амьдарч байна.


2018 оны нийт хүн амын тоог 2017 оны хүн амын тоотой харьцуулж үзвэл 2587 хүнээр буюу 3.2 хувиар, өрхийн хувьд 494 өрхөөр буюу 2.1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Хэрлэн сум 46609 хүн ам тоолуулсан байна. 3000-аас дээш хүн амтай Баяндун, Баян-Уул, Дашбалбар, Халхгол, Цагаан-овоо, нийт 5 сум байгаа юм.

Хүн амын тооны өөрчлөлт




Өрхийн тооны өөрчлөлт



Аймгийн хэмжээнд 2018 оны 12 сарын байдлаар 1948 эх амаржиж, 1957 хүүхэд төрж, нас баралт 436 болж өмнөх оны мөн үеэс амаржсан эх 26 (1.3%)-аар, төрсөн хүүхэд 23 (1.2%)-аар, нас баралт 6 (1.4%)-аар тус тус өсчээ.

1000 хүнд ногдох төрөлт 24.89, нас баралт 5.54, ердийн цэвэр өсөлт 19.3 болов.

Зураг. I Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2014-2018 оны 12 сард



Эрүүл мэнд: 2018 оны жилийн эцсийн байдлаар 1948 эх амаржиж, нийт нас баралт 436 тохиолдол бүртгэгдсэн. Нас баралтын шалтгааныг төрлөөр нь авч үзвэл хорт хавдрын нас баралт 139 тохиолдол бүртгэгдсэн ба нийт нас баралтын 31.9%, осол гэмтлийн нас баралт 73 тохиолдол буюу 16.7%-ийг тус тус эзэлж байна.

Хүн амын дотор өвчлөл 40.3 мянган тохиолдол бүртгэгдэж, 142.9 мянган ор хоног ашиглажээ. Амбулаториор 387.1 мянган хүнд үзлэг хийж, эмнэлэгт 19.2 мянган хүнийг хэвтүүлэн эмчилжээ.

Халдварт өвчнөөр өвчлөгчид 2018 оны 12 сард 2816 болж, өмнөх оны мөн үеийнхээс 99 хүн буюу 96.6 хувиар буурахад салхин цэцгээр өвчлөгчдийн тоо 584 (20%), заг хүйтэн өвчнөөр 1058 (37.5%) тохиолдол, трихоминиаз 414 (14.7%) тохиолдол тус тус бүртгэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Хувийн хэвшлийн эмнэлэг эмийн сангууд 250.2 мянган хүнд үйлчилж, 2498.0 сая төгрөгийн орлоготой ажиллалаа.



Боловсрол: Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 26 сургуулийн 545 бүлэгт 15.4 мянган хүүхэд суралцаж байна. Дотуур байранд амьдрах хүсэлтийг 992 хүүхэд гаргаснаас 915 хүүхэд амьдарч байна.

Ерөнхий боловсролын 26 сургуульд 798 багш, 37 цэцэрлэгийн 228 бүлэгт 7.0 мянган хүүхэд хүмүүжиж, 438 үндсэн болон туслах багш ажиллаж байна.



Санхүү, төсөв: Орон нутгийн нийт орлого 62162.4 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 63629.7 сая төгрөг, үүнээс татварын орлого 16901.6 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 17473.9 сая төгрөгт хүрч 572.3 сая төгрөгөөр, татварын бус орлого 45261.3 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 446155.8 сая төгрөгт хүрч 894.4 сая төгрөгөөр тус тус даван биеллээ.

Аймгийн төсвийн нийт зарлага 62001.6 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 59396.5 сая төгрөгийн гарсан гүйцэтгэлийг бүрэн санхүүжүүлсэн.

Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээр 4591.1 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт 3650.4 сая төгрөг, аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгт 4139.2 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр 30488.6 сая төгрөгийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн санхүүжүүллээ.



Хөдөө аж ахуй: 2018 оны жилийн эцсийн мал тооллогоор 2377.8 мянган толгой мал тоологдсон ба үүнээс тэмээ 6.1 мянга, адуу 278.8 мянга, үхэр 243.1 мянга, хонь 1147.7 мянга, ямаа 702.1 мянга тус тус тоологдов. Нийт малын тоо өмнөх оноос 319975 толгойгоор өссөн ба 5 төрлөөр нь авч үзвэл өмнөх оноос Тэмээ 484, Адуу 28093, Үхэр 35279, Хонь 146118, Ямаа 110001 толгойгоор тус тус өссөн байна.

2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр хамгийн их малтай сум Дашбалбар сум 292137 толгой мал тоолуулсан бол хамгийн бага малтай Халхгол сум 77670 толгой мал тоолуулсан байна.

Тайлант онд Булган, Гурванзагал, Матад, Халхгол сумдаас бусад 10 сум малаа 5 төрөл дээрээ өсгөсөн байна.

Хээлтэгч малын тоо 12.6 хувь буюу 116.9 мянган толгойгоор өмнөх оныхоос өсч, хээлтэгч мал 1048091 толгой болсон байна.

Нийт малын 97.4 хувь нь буюу 2315.5 мянган толгой мал амины аж ахуйд тоологдсон бол 2.6 хувь нь албан газар аж ахуйн нэгжийн мэдэлд байгаа юм.

Малтай өрхийн тоо 7295 болж өмнөх оноос 3.6 хувиар, малчин өрхийн тоо 5093 болж өмнөх оноос 1.3 хувиар тус тус өссөн байна.

Таван зуугаас дээш малтай айл өрхийн тоо 1465 болсны дотор 484 айл өрх нь 1000-аас дээш малтай болжээ. Таван зуугаас дээш малтай өрхийн тоо өмнөх оныхоос 29.3 хувь буюу 332 өрхөөр 1000-аас дээш малтай өрхийн тоо 32.6 хувиар буюу 119 айл өрхөөр тус тус өссөн байна.

Мал бүхий иргэд, малчид 2018 онд 827.3 мянган төл бойжуулж, бойжсон төлийн тоо өмнөх оныхоос 170.1 мянган толгойгоор өссөн.

Том малын зүй бусын хорогдол 6.6 мянгад хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 27.7 хувиар буюу 2523 толгойгоор буурсан байна.

Жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогоор гахай 655 болж 20.8 хувиар, бүл зөгий 899 болж 1.4 хувиар өсч, шувуу 6202 болж 55.4 хувиар буурсан байна.

Нар салхины болон бусад цахилгааны эх үүсвэртэй өрх 4078, телевизортой өрх 3379, автомашинтай өрх 3017, мотоциклтой өрх 1712, трактортой өрх 438 болсон байна.

Малгүй айл өрхийг малжуулах арга хэмжээний хүрээнд төсөл болон орон нутгийн санхүүжилтээр 580.9 сая төгрөг зарцуулж 171 айл өрхийг 8.4 мянган толгой малтай болголоо. Энэ онд шинээр 107 худаг гаргаж, 70 худаг засварлажээ.

Худаг шинээр гаргахад улсын төсөв, төсөл болон малчдаас 859.5 сая, засварлахад төсөв, төсөл болон иргэдээс 135.3 сая төгрөг зарцуулсан байна.

2018 онд 13156 га-д улаан буудай, 183.3 га-д төмс, 162.5 га-д хүнсний ногоо тариалж, 13395 тн улаан буудай, 1960.5 тн төмс, 1353.1 тн хүнсний ногоог тус тус хураан авлаа.

Мал бүхий иргэд, аж ахуйн нэгжүүд 74.5 мянган тн хадлан бэлтгэлээ.



Аж үйлдвэр: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 58.8 тэрбум төгрөг болж урьд оны мөн үеийнхээс 1.2 тэрбум төгрөгөөр буюу 2.1 хувиар өссөн бол оны үнээр 55.6 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 0.8 тэрбум төгрөгөөр буюу 1.4 хувиар буурсан гүйцэтгэлтэй байна.

Энэ онд гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс 533.6 мянган тонн нүүрс олборлож, 254294.9 мянган.квт.цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, 287611 г.кал дулаан нийлүүлж, 3920.2 тн гурил, 1271 тн хивэг тус тус үйлдвэрлэсэн байна.




Тээвэр, харилцаа, холбоо:

Аймгийн Холбооны салбарын нийт орлого 291.2 сая төгрөгт хүрсний 22.2 хувийг хүн амаас орсон орлого эзэлж байна.

Шуудан тээврийн газар 82 135.6 мян.төгрөгийн орлоготой ажиллаж, 7 600 бичиг захидал, 227 илгээмж, 60 355 хэвлэл илгээж, 20 246 бичиг захидал, 1 236 илгээмж, 105 755 хэвлэл хүлээн авч хүргэсэн байна.

Авто тээврийн төв ТӨҮГ 38.5 мянган зорчигч тээвэрлэж, 24765.8 мянган хүн км-ийн зорчигч эргэлтийн ажил гүйцэтгэн 102156.2 мянган төгрөгийн орлоготой ажиллажээ.

Зураг. II Тээсэн зорчигчдын тоо, мянган хүн,
жил бүрийн 12 сарын байдлаар



Барилга, нийтийн аж ахуй: 2018 онд нийтийн аж ахуй үйлчилгээний байгууллагын нийт орлого 3202.5 сая төгрөгт хүрснээс ус борлуулалтын орлого 1164.1 сая төгрөг буюу 36.3 хувийг эзэлж байна.

Дорнод аймгийн хэмжээнд энэ онд барилга угсралт, их засвар, замын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 40 гаруй аж ахуйн нэгж байгууллага төрийн болон хувийн хөрөнгөөр 23688.9 сая төгрөгийн ажлыг хийж гүйцэтгэсэн байна.



Хөдөлмөр эрхлэлт: Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо эхний 12 сарын байдлаар нийт бүртгэлтэй ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 505 хүнээр буюу 29.4 хувиар, өмнөх сараас 322 хүнээр буюу 20.9 хувиар тус тус буурч 1215 болсны 622 буюу 42.5 хувь нь эмэгтэйчүүд эзэлж байна.

2018 оны 12 сарын байдлаар хөдөлмөрийн хэлтэст 1021 иргэн шинэ ажлын байранд ажиллаж байна.

Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 63.1 хувь нь 15-34 насны залуучууд байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 23.3 хувь нь дээд болон магистр, 6.7 хувь нь тусгай дунд, 12.3 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 48.8 хувь нь бүрэн дунд, 5.1 хувь нь суурь, 2.2 хувь нь бага боловсролтой, 1.6 хувь нь боловсролгүй хүмүүс байна.



Гэмт хэрэг: Энэ оны эхний 12 сард 602 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 44 хүн нас барж, 219 хүн гэмтэж бэртсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 20 хэргээр буюу 3.4 хувиар өссөн байна.

Гэмт хэргийн улмаас аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд 3121.8 сая төгрөгийн хохирол учирсны 26.5 хувь буюу 826 сая төгрөгийг нөхөн төлүүлсэн байна. Нийт гарсан гэмт хэргийн 130 хэргийг 172 хүн согтуугаар үйлдсэн байна.

Үйлдэгдсэн бүх хэргийн 213 буюу 35.4 хувь нь хулгайн хэрэг, үүнээс малын хулгайн хэрэг 101 буюу 47.4 хувийг эзэлж байна. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь аймгийн хэмжээнд 54.8 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.3 пунктээр өссөн байна.



Хэрэглээний үнэ: Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2018 оны 12 дугаар сард өмнөх сараас 0.8 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 6.3 хувиар өслөө. **Ерөнхий индекс 2018 оны 12 сард өмнөх сараас 0.8 хувиар** өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг, гэр ахуйн тавилга, амралт, чөлөөт цаг, соёлын үйлчилгээний бүлгийн үнэ тус тус өссөн нь нөлөөлжээ.



Нийгмийн даатгал, халамж: Нийгмийн даатгалын сангаас 2018 онд тэтгэвэр, тэтгэмж олгоход нийт 46803.6 сая төгрөгийг зарцуулжээ. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо 11812 байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.7 хувиар өссөн байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн санд 23045.7 сая төгрөг төвлөрүүлснээс 2324.0 сая төгрөгөөр буюу 10.1 хувиар давуулан биелүүлсэн. Сайн дурын даатгалд 1733.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 99.2 хувийн биелэлттэй байна.

Тайланд онд нийгмийн даатгалын сангаас тэтгэмж авагчдын тоо 5008 болж өмнөх оноос 2.1 хувиар өсч, 2727.6 сая төгрөгийг тэтгэмжээр олгосон байна.



Мөнгө, банк: Дорнод аймгийн хэмжээнд 2018 онд нийт зээлийн хэмжээ 227567.8 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй, хугацаа хэтэрсэн зээл 3243.9 сая, чанаргүй зээл 3757.1 сая төгрөг байна. Хугацаатай хадгаламжинд 67439.2 сая төгрөг, хугацаагүй хадгаламжинд 29406.1 сая төгрөг, харилцах дансанд 41305.2 сая төгрөг тус тус хадгалуулсан байна.



Худалдан авах ажиллагааны мэдээлэл: Төсөл арга хэмжээний жагсаалтад нийт 5,8 тэрбум төгрөгийн 141 төсөл, арга хэмжээ тусгаснаас орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 2,101.5 сая төгрөгийн 61, Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 346.1 сая төгрөгийн 8, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 2,415.8 сая төгрөгийн 37, Байгаль орчныг

хамгаалах, нөхөн сэргээх зардлаар хэрэгжүүлэх 1,030.5 сая төгрөгийн 35 хөтөлбөр, арга хэмжээ тус тус байна.

Зохион байгуулсан тендер шалгаруулалтад давхардсан тоогоор нийт 142 оролцогч оролцож, 107 этгээдтэй гэрээ байгуулсан байна. Үүнээс орон нутгийн гүйцэтгэгч 82 буюу 77 хувь нь байна.

Тайлант хугацаанд 12,3 тэрбум төгрөгийн 115 тендер шалгаруулалт зохион байгуулахаас 107 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 11,7 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан байна. Энэ нь тендер шалгаруулалтаас 656.4 сая төгрөгийн хэмнэлт гарсан байна.

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.ЭНХБААТАР